

1999 ОНЫ МАЛ ТООЛЛОГО

ОРШИЛ

1999 оны байдлаар манай орны эдийн засгийн үндсэн гол салбарын нэг болох хөдөө аж ахуйд нийт ажиллагсадын 48.5 гаруй хувь ажиллаж, дотоодын нийт бүтээгдэхүүний 35.1 орчим хувийг үйлдвэрлэж; экспортод хоёрдогч байр суурийг эзлэж байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 80 гаруй хувийг эзэлдэг мал аж ахуйн салбарын хөгжил, түүний бүтээгдэхүүний өсөлтөөс улс орны эдийн засгийн бусад салбар ихээхэн шалтгаалдаг билээ. Нийт малын тоо 1999 оны эцэсд 33.6 саяд хүрч, 1998 оныхоос 671.4 мянган толгойгоор өслөө.

Монгол улсын Засгийн газар мал тооллогыг жил бүр оны эцэст явуулж байх тухай 140 дугаар тогтоол гаргасан нь ихээхэн ач холбогдолтой болов.

Мал тооллогын бэлтгэл зохион байгуулалтыг хангах, маягт, зааварчилгааг орон нутагт хүргүүлэх, тооллогын маягт, заавар аргачлалд гарсан өөрлөлтийн талаар Үндэсний статистикийн газраас нийт аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар, статистикийн албадад семинар, удирдамж өгч ажиллав.

Аймаг, сум, нийслэл, дүүргүүдэд мал тооллогын ажлыг удирдан зохион байгуулж явуулах комисс ажиллуулж, нэгдсэн семинар зөвлөгөөн орон нутагт зохиогдон, тооллогын үеэр сумдад хяналт шалгалтын групп томилон ажиллуулав.

Зудын байдалд орсон Дундговь, Баянхонгор зэрэг аймагт мал тооллогын ажлыг зохион байгуулахад хүндрэл учирч, нэмэгдэл зардал гарсан боловч тооллогын ажил хэвийн хэмжээнд явагдсан байна.

1999 оны мал тооллогын ажлыг зохих заавар журмын дагуу явуулж, мал сүргийг тооллогод бүрэн хамруулах, тооллогын үнэн зөв байдлыг хангуулах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний тамгын газраас зориуд анхаарч, дэмжлэг тусалцаа үзүүлэн зохион байгуулсныг тэмдэглэж байна.

II. МАЛ ТЭЖЭЭВЭР АМЪТАДЫН ТОО, БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

II.1. Малын тоо, бүрэлдэхүүн, тархалт.

Малын тооны өсөлт. 1999 оны эцэст 33.6 сая мал тоологдсон нь 1998 оныхоос 2.0 хувь буюу 671.4 мянган толгойгоор өслөө. Урьд оныхоос хонь 497.1 мянга, үхэр 98.9 мянга, адуу 104.4 мянгаар нэмэгдэж, харин тэмээ 0.9 мянга, ямаа 28.0 мянгаар хорогдсон байна.

Бодод шилжүүлснээр малын тоо урьд оныхоос 2.5 хувь буюу 281.1 мянгаар өсөв.

Малын тоо (мян.тол)

	1990	1995	1997	1998	1999	1999/1998	
						%	Зөрүү
Бодоор *	9071.5	9868.2	10683.2	11151.5	11432.6	102.5	281.1
Толгойн тоо	25856.9	28572.3	31292.3	32897.5	33568.9	102.0	671.4
Тэмээ	537.5	367.5	355.4	356.5	355.6	99.7	-0.9
Адуу	2262.0	2648.4	2893.2	3059.1	3163.5	103.4	104.4
Үхэр	2848.7	3317.1	3612.9	3725.8	3824.7	102.7	98.9
Хонь	15083.0	13718.6	14165.6	14394.2	15191.3	103.4	497.1
Ямаа	5125.7	8520.7	10265.3	11061.9	11033.9	99.7	-28.0

* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг нэг бод, тэмээг 1.5 бод, 6 хонь, 8 ямааг тус бүр нэг бод гэж тооцов.

16 аймаг урьд онд байсан малаа толгойн дүнгээр өсгөсний дотор Архангай, Булган, Дорноговь, Сүхбаатар, Ховд, Дархан-Уул, Орхон аймаг таван төрөл дээр нь өсгөв.

Дундговь, Завхан аймгийн малын тоо 4.9 – 6.6 хувь буюу 107.5 – 171.6 мянган толгойгоор буурсан байна.

Тэмээн сүргийн тоо 13 аймагт өссөн боловч Увс аймагт 1.6 мянга, Дундговьд 1.0 мянга, Говь-Алтайд 0.8 мянгаар буурснаас голлон шалтгаалж улсын хэмжээгээр урьд оныхоос 0.9 мянган толгойгоор хорогджээ. (Хавсралт хүснэгтийн 3, 5- р хүснэгтээс үзнэ үү. Цаашид хавсралт хүснэгтийн хуудасны дугаарыг заана)

Сүүлийн жилүүдэд малын тоо толгой нийт дүнгээрээ өсч байгаа боловч төрөл дотроо өсөлт жигд биш байна. Өнгөрсөн өсөн жил буюу 1991 – 1999 онд манай улсын мал сүргийн тоо 7 жилд нь өсч, 29.8 хувь буюу 7.7 саяаар нэмэгджээ. Энэ өсөлтийн 5.9 сая буюу 76.6 хувийг нь ямаан сүргийн өсөлт эзэллэж байна.

Сүүлийн 9 жилд малын өсөлтийг төрлөөр үзүүлбэл

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өссөн жилийн тоо	7	2	6	6	4	8
Буурсан жилийн тоо	2	7	3	3	5	1
1999 оныхоос өссөн хэмжээ (мян.тол)	7893.9		901.4	976.0	108.3	5908.2
1990 оныхоос буурсан хэмжээ (мян.тол)	181.9	181.9				

Өнгөрсөн есөн жилд Орхон, Өмнөговь, Дархан-Уул, Булган, Архангай, Баянхонгор аймаг, Улаанбаатар хотын малын тоо 1.5 – 3.1 дахин өссөн байна. Харин Дорнод, Хэнтий аймгийн малын тоо 36 – 125 мянган толгойгоор хорогджээ.

Нийт малын тооны өсөлт, аймгаар

	Толгойн тоо (мян.тол)					1999\1998	
	1990	1995	1997	1998	1999	хувь	зөрүү
Архангай	1496.3	1626.4	1924.2	2119.3	2335.5	156.1	839.3
Баян-Өлгий	1318.4	1354.2	1519.4	1345.9	1362.4	103.3	44.0
Баянхонгор	1599.1	2227.1	2428.0	2511.3	2475.1	154.8	876.0
Булган	998.2	1137.1	1309.8	1458.9	1609.3	161.2	611.1
Говь-Алтай	1693.6	2102.5	2112.5	2113.1	2113.2	124.8	419.6
Дорноговь	843.3	886.2	963.2	1017.8	1110.2	131.6	266.9
Дорнод	936.6	591.4	657.2	735.7	811.8	86.7	-124.9
Дундговь	1505.5	1714.4	2025.7	2212.8	2105.2	139.8	599.7
Завхан	2133.4	2401.4	2556.5	2603.6	2432.0	114.0	298.6
Өвөрхангай	2061.6	2595.0	2718.2	2921.5	2956.6	143.4	895.0
Өмнөговь	910.9	1203.5	1508.4	1603.8	1608.9	176.6	698.0
Сүхбаатар	1004.7	1015.6	1133.1	1288.2	1450.6	144.4	445.9
Сэлэнгэ	512.5	504.7	522.5	569.4	622.6	121.5	110.1
Төв	1711.4	1766.4	2048.4	2238.5	2218.1	129.6	506.7
Увс	1666.6	1754.2	1856.3	1940.1	1889.8	113.4	223.2
Ховд	1687.7	2070.6	1926.5	1795.9	1867.9	110.7	180.2
Хөвсгөл	1871.9	1857.4	2152.3	2295.8	2418.2	129.2	546.3
Хэнтий	1498.7	1100.9	1254.0	1388.7	1462.3	97.6	-36.4
Дархан-Уул	109.2	138.6	136.8	168.2	179.4	164.2	70.1
Улаанбаатар	143.6	294.3	301.2	301.0	239.4	166.7	95.8
Орхон	53.5	127.3	120.3	132.3	163.9	306.4	110.4
Говьсүмбэр	100.2	103.1	117.8	135.7	136.5	136.2	36.3

Манай орны түүхэнд 1999 онд хамгийн олон мал, үүний дотор хамгийн олон адуу, үхэр тоологдов.

Малын тоо толгойн хүрсэн дээд хэмжээг үзүүлбэл:

	1918 оноос хойш		Жилийн эцэст тоолдог болсон 1961 оноос хойш	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	33568.9	1999	33568.9	1999
Тэмээ	895.3	1954	751.7	1961
Адуу	3163.4	1999	3163.5	1999
Үхэр	3824.7	1999	3824.7	1999
Хонь	15936.4	1941	15191.3	1999
Ямаа	11061.9	1998	11061.9	1998

1990 оноос хойш нийт сүрэгт тэмээ, хонины эзлэх хувийн жин жилээс жилд буурч байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	1990	1993	1995	1996	1997	1998	1999
Тэмээ	2.1	1.5	1.3	1.2	1.1	1.1	1.1
Адуу	8.8	8.7	9.3	9.4	9.3	9.3	9.4
Үхэр	11.0	10.8	11.6	11.9	11.5	11.3	11.4
Хонь	58.3	54.7	48.0	46.3	45.3	44.7	45.2
Ямаа	19.8	24.3	29.8	31.2	32.8	33.6	32.9
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Улсад нийт малын тоогоор Өвөрхангай, тэмээгээр Өмнөговь, адуугаар Төв, үхрээр Хөвсгөл, хониор Өвөрхангай, ямаагаар Баянхонгор тэргүүн байранд байна. (Хавсралтын хуудасны дугаар 1)

Манай улс дэлхийн улс орнуудын дотор адуугаар 6 дугаар, тэмээгээр 12, ямаагаар 12, хониор 17, үхрээр 55 дугаар байранд орж байна.

Ази тивд адуугаар 2 дугаар, тэмээгээр 4, хониор 6, ямаагаар 7, үхрээр 15 дуугаар байранд орж байна.

Адуу, тэмээ, ямааны тоогоор (мян.тол)

Улсын нэр	Адууны тоо	Улсын нэр	Тэмээний тоо	Улсын нэр	Ямааны тоо
1.Хятад	8855	1.Сомали	6100	1.Хятад	137717
2.Бразил	6400	2.Судан	3100	2.Энэтхэг	120560
3.Мексик	6250	3.Мавритан	1183	3.Пакистан	48575
4.АНУ	6150	4.Пакистан	1100	4.Судан	37346
5.Аргентин	3300	5.Энэтхэг	1030	5.Бангладеш	33500
6.Монгол	3163	6.Этиоп	1030	6.Иран	27000
7.Этиоп	2750	7.Кени	825	7.Нигери	24500
8.Колумби	2300	8.Чад	677	8.Этиоп	16850
9.Орос	1312	9.Саудын араб	422	9.Индонези	15200
10.Казахстан	1083	10.Нигер	392	10.Бразил	12600
		11.Мали	365	11.Сомали	12500
		12.Монгол	356	12.Монгол	11034

Тайлбар: Дэлхийн улсуудын малын тоог 1998 оноор авсан болно.

Манай улс дэлхийд нэг хүн амд ногдох адуу, ямаагаар тэргүүн байр, тэмээ, хониор 3-р байранд тус тус орж байна.

Нэг хүн амд ногдох малын тоогоор эхний байруудад ордог
улс орнуудыг үзүүлбэл : (толгой)

Адуугаар		Тэмээгээр		Хониор		Ямаагаар	
1. Монгол	1.32	Сомали	0.60	Шинэзеланд	12.54	Монгол	4.62
2. Аргентин	0.09	Мавритан	0.47	Австрали	6.46	Мавритан	1.63
3. Казахстан	0.07	Монгол	0.15	Монгол	6.33	Сомали	1.35
4. Мексик	0.07	Судан	0.11	Уругвай	5.41	Судан	1.32
5. Колумби	0.06	Чад	0.09	Судан	1.50	Мали	0.80

Хувийн (амины) малын тоо. 1999 онд улсын хэмжээгээр аминдаа малтай 270.0 мянган өрх тоологдсоны дотор 70.3 хувь буюу 189.9 мянга нь малчин өрх, 29.7 хувь буюу 80.1 мянга нь мал бүхий бусад иргэдийн өрх байна. Хувийн малын тоо 1990 онд нийт малын 31.9 хувь байснаа 1999 онд 96.2 хувийг эзлэх болов. Хувийн малын тоо 32.3 саяд хүрч, өнгөрсөн 9 жилд 3.9 дахин нэмэгдэв.

Хонины 94.2 хувь, бусад төрлийн малын 97.4 – 97..9 хувь нь хувийн аж ахуйд ногдох болжээ.

Өнгөрсөн онд Баянхонгор, Дундговь, Завхан аймаг, Улаанбаатар хотын хувийн малын тоо урьд оныхоос буурсан байна.

Хувийн малын өсөлт, аймгаар

	Толгойн тоо (мян.тол)					1999\1998	
	1990	1995	1997	1998	1999	хувь	Зөрүү
Архангай	565.4	1577.9	1900.8	2096.7	2316.0	409.6	1750.6
Баян-Өлгий	607.6	1324.6	1494.7	1330.7	1349.3	222.0	741.6
Баянхонгор	505.1	2134.8	2359.3	2477.0	2445.7	484.2	1940.6
Булган	273.7	1018.6	1210.0	1382.0	1543.1	563.8	1269.4
Говь-Алтай	525.8	2044.3	2070.7	2077.7	2079.0	395.4	1553.3
Дорноговь	253.0	776.5	867.4	926.4	1018.9	402.7	765.9
Дорнод	169.4	466.9	549.6	636.8	714.5	421.8	545.1
Дундговь	438.6	1660.8	1970.5	2157.8	2063.5	470.5	1624.9
Завхан	676.4	2330.4	2505.6	2560.1	2404.4	355.5	1728.0
Өвөрхангай	801.4	2465.3	2611.8	2829.8	2881.6	359.6	2080.3
Өмнөговь	303.8	1159.6	1458.5	1555.6	1564.2	514.8	1260.4
Сүхбаатар	286.8	894.8	1042.5	1209.6	1377.7	480.4	1091.0
Сэлэнгэ	123.1	314.0	371.1	442.4	511.8	415.9	388.8
Төв	512.3	1420.8	1747.2	1968.8	2010.0	392.3	1497.7
Увс	550.1	1657.0	1780.7	1880.7	1847.5	335.8	1297.3
Ховд	584.0	1944.5	1845.0	1728.4	1829.0	313.2	1245.0
Хөвсгөл	605.9	1789.1	2102.1	2246.5	2377.1	392.4	1771.2
Хэнтий	308.8	959.7	1103.3	1231.0	1316.1	426.2	1007.3
Дархан-Уул	38.0	102.4	103.8	139.3	153.7	404.9	115.8
Улаанбаатар	77.5	250.2	256.0	268.2	218.6	282.0	141.1
Орхон	19.3	95.4	99.3	113.8	150.2	777.9	130.9
Говьсүмбэр	16.9	59.6	79.1	96.9	106.9	632.5	90.0
ДҮН	8242.9	26447.2	29529.0	31356.3	32278.7	391.6	24035.9

Хувийн аж ахуйд байгаа малын бүтцыг авч үзвэл хонь 44.3 хувь, ямаа 33.4, үхэр 11.6, адуу 9.6, тэмээ 1.1 хувийг эзлэж байна.

Хувийн аж ахуйн мал, төрлөөр (мян.тол)

	Малтай өрхийн тоо	Бүгд	Ү Ү Н Э Э С				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1990	262.3	8242.9	88.2	1108.1	1457.5	3684.7	1904.4
1991	288.9	14002.6	186.3	1492.1	1896.6	7209.4	3218.2
1992	301.5	18081.1	253.7	1728.0	2237.4	9589.1	4272.9
1993	289.7	22565.2	335.0	2026.8	2503.5	11902.0	5797.9
1994	289.2	24527.2	343.3	2279.0	2811.8	12133.8	6959.3
1995	283.9	26447.2	349.7	2532.0	3140.4	12194.1	8231.0
1996	278.3	27365.2	342.6	2670.6	3323.4	12184.6	8844.0
1997	279.7	29529.0	343.8	2807.4	3485.3	12912.0	9980.5
1998	275.0	31356.3	346.4	2982.6	3613.5	13630.1	10783.8
1999	270.0	32278.7	346.6	3097.3	3733.2	14306.5	10795.3

Иргэдийн хувийн малын бүлэглэлтээс үзвэл 100 хүртэл малтай ядуу, ядуувтар өрх нийт малтай өрхийн 58.4 хувийг эзлэж байна.Тэрчлэн малтай өрх бүрийн дөрөвний нэг нь 101 – 200 толгойгоос хэтрэхгүй малтай байна.

1998 онд малчдын дунд явуулсан түүвэр судалгаагаар нэг малчин өрхийн дундаж орлого 500.2 мянган төгрөг, сарынх нь 41.7 мянган төгрөг байв. 10 хүртэл малтай малчин өрхийн жилийн дундаж орлого 63.2 мянган төгрөг байхад 2000-аас дээш малтай өрхийн жилийн дундаж орлого 4.5 сая төгрөг байв.

Иргэдийн хувийн малын бүлэглэлт

	Малтай өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо	
	1998	1999	1998	1999	1998	1999
10хүртэл малтай	31668	28669	11.5	10.6	170.5	164.3
11-30 малтай	36837	35970	13.4	13.3	758.0	743.4
31-50 малтай	33733	31874	12.3	11.8	1382.2	1325.4
51-100 малтай	62941	61347	22.9	22.7	4731.9	4710.9
101-200 малтай	67466	67840	24.5	25.1	9469.1	9598.4
201-500 малтай	36275	37635	13.2	14.0	10496.1	10874.8
501-999 малтай	5112	5438	1.9	2.0	3205.0	3447.7
1000-1499 малтай	860	1061	0.3	0.4	967.3	1196.3
1500-2000 малтай	62	75	0.0	0.0	101.4	124.8
2001-ээс дээш малтай	33	41	0.0	0.0	74.4	92.8
ДҮН	274987	269950	100.0	100.0	31355.9 *	32278.6*

- Бүлэглэлтэд алдуул мал ороогүй

Одоо 50 хүртэл малтай өрхүүд үндсэндээ дөрвөн хошуу малтай байгаагийн дотор 10 хүртэл малтай өрх дунджаар 1 адуу, 3 үхэр, 2 бог малтай байна.

Нэг өрхөд ногдох хувийн малын бүлэглэлт 1999 оны байдлаар (толгой)

	Бүгд	Ү ү н э э с				
		тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
10хүртэл малтай	5.7	0.0	0.8	3.2	0.8	0.9
11-30 малтай	20.7	0.1	2.9	6.7	5.4	5.7
31-50 малтай	41.6	0.2	5.0	9.0	14.1	13.4
51-100 малтай	76.8	0.5	8.5	12.5	29.7	25.6
101-200 малтай	141.5	1.3	13.6	15.9	61.7	49.0
201-500 малтай	289.0	4.2	25.8	24.3	133.7	100.9
501-999 малтай	634.0	8.8	52.6	47.0	326.1	199.5
1000-1499 малтай	1127.6	11.8	92.8	79.6	646.3	297.1
1500-2000 малтай	1663.5	12.3	140.2	110.6	1038.8	361.6
2001-с дээш малтай	2262.8	17.3	152.5	153.9	1469.9	469.3
ДҮН	119.6	1.3	11.5	13.8	53.0	40.0

Улсын дунджаар малтай нэг өрхөд (бодод шилжүүлснээр) 41 бод буюу 120 толгой хувийн мал ногдож байна. Харин говийн гурван аймагт 162 – 204 толгой мал ногдож байна.

Малтай нэг өрхөд ногдох хувийн малын тоо

	Бодод шилжүүлснээр			Толгойн тоогоор		
	1997	1998	1999	1997	1998	1999
Архангай	37.8	41.1	44.2	85	95	103
Баян-Өлгий	28.4	24.8	24.5	101	88	88
Баянхонгор	39.1	41.3	42.1	137	145	146
Булган	43.4	49.6	53.1	101	119	130
Говь-Алтай	39.5	40.1	39.3	161	164	163
Дорноговь	51.0	54.1	58.9	140	149	162
Дорнод	28.0	34.1	37.4	60	76	84
Дундговь	59.1	61.9	62.6	194	204	204
Завхан	43.0	44.5	44.0	133	140	137
Өвөрхангай	36.5	39.5	40.8	111	122	124
Өмнөговь	53.2	57.3	56.1	174	187	181
Сүхбаатар	42.3	47.3	54.2	103	119	136
Сэлэнгэ	14.0	16.5	18.8	34	42	49

Төв	37.4	42.0	43.8	95	109	116
Увс	31.2	33.2	33.1	100	108	112
Ховд	36.8	35.6	38.9	126	124	137
Хөвсгөл	37.8	39.4	41.9	90	96	101
Хэнтий	40.3	46.0	50.3	92	109	119
Дархан-Уул	10.4	10.9	16.7	25	28	43
Улаанбаатар	11.5	12.9	12.5	28	33	29
Орхон	17.3	21.9	27.2	42	56	73
Говьсүмбэр	25.5	30.9	34.5	67	85	94
ДҮН	36.5	39.0	41.1	106	114	120

Хээлтэгч мал. 1999 оны эцэст 14154.4 мянган хээлтэгч мал тоологдсон нь урьд оныхоос 228.9 мянгаар өссөний дотор эм хонь 178.6, гүү 84.9 мянга, үнээ 17.0 мянга, ингэ 3.5 мянгаар нэмэгдэж, эм ямаа 55.1 мянгаар буурсан байна.

Хээлтэгч малын тоо (мян.тол)

	1990	1995	1997	1998	1999	1999\1998	
						Хувь	Зөрүү
Ингэ	140.9	101.3	97.7	97.9	101.4	103.6	3.5
Гүү	563.5	707.1	783.2	836.6	921.5	110.1	84.9
Үнээ	1127.1	1177.8	1370.8	1432.8	1449.8	101.2	17.0
Эм хонь	7786.1	5948.3	6370.6	6667.9	6846.5	102.7	178.6
Эм ямаа	2425.7	3607.7	4473.2	4890.3	4835.2	98.9	-55.1
ДҮН	12043.3	11542.2	13095.5	13925.5	14154.4	101.6	228.9

Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Завхан, Увс, Ховд аймаг, нийслэл хотоос бусад аймаг хээлтэгч малынхаа тоог урьд оныхоос өсгөсөн байна. (Хавсралтын хуудасны дугаар 15 – 17)

1961 оноос хойш олон хээлтэгч мал тоологдсон жил

	мян.тол	он		мян.тол	Он
Ингэ	226.9	1961	Эм хонь	7786.1	1990
Гүү	921.5	1999	Эм ямаа	4890.3	1998
Үнээ	1449.8	1999			

Төл бойжилт. 1999 онд гарсан төлийн 90.5 хувь буюу 10220.9 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 313.6 мянгаар нэмэгджээ. Бойжуулсан нийт төлөөс 5.5 мянгыг каракуль арьсанд нядалсан байна.

Төл бойжилт (мян.тол)

	Бүгд	Ү Ү Н Э Э С					1999\1998 зөрүү
		ботго	унага	тугал	хурга	ишиг	
Гарсан	11288.9	42.5	575.4	1091.1	5673.8	3906.2	332.9
Бойжсон	10220.9	37.9	527.9	1035.3	5245.4	3374.4	313.6
Хорогдсон	1068.0	4.6	47.5	55.8	428.4	531.7	19.3
Бойжилтын хувь	90.5	89.2	91.7	94.9	92.4	86.4	

Бойжуулсан төл (мян.тол)

	1991-1995 оны дундаж	1994	1995	1996	1997	1998	1999
Ботго	42.3	36.7	40.5	37.0	39.3	38.4	37.9
Унага	357.4	387.6	451.2	467.2	471.9	516.5	527.9
Тугал	778.1	812.9	920.4	918.1	944.6	980.0	1035.3
Хурга	5431.3	5085.2	4969.2	4873.3	4946.4	5094.5	5245.4
Ишиг	2141.5	2307.6	2631.1	2751.9	3135.1	3277.9	3374.4
Бүгд	8750.6	8630.0	9012.4	9047.5	9537.3	9907.3	10220.9

1999 онд хамгийн олон ишиг, тугал, унага бойжуулан авлаа.

1961 оноос хойш хамгийн олон төл бойжуулсан жил

	мян.төл	он		мян.төл	Он
Бүгд	10220.9	1999	Тугал	1035.3	1999
Ботго	74.4	1975	Хурга	6569.6	1989
Унага	527.9	1999	Ишиг	3374.4	1999

1999 онд 100 эхээс бойжуулсан төлийг өмнөх оныхтой зэрэгцүүлж үзвэл унага 3, хурга 1, ишиг 4-өөр бага байна.

100 эхээс бойжуулсан төл

	1991-1995 оны дундаж	1994	1995	1996	1997	1998	1999
Ботго	36	37	40	37	40	39	39
Унага	61	67	69	66	64	66	63
Тугал	72	78	79	78	78	72	72
Хурга	77	79	79	82	85	80	79
Ишиг	78	80	80	76	81	73	69
Бүгд	76	78	78	78	81	76	74

100 хээлтэгчээс Архангай, Баян-Өлгий, Булган, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Орхон аймаг 80-90 төл бойжуулсан байхад Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай, Төв аймаг, Улаанбаатар хот 45-67 төл бойжуулжээ. (Хавсралтын хуудасны дугаар 20)

Том малын зүй бус хорогдол. 1999 оны эхний малын 2.4 хувьтай тэнцэх 800.1 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оныхоос 14.3 мянгаар их, 1991-1995 оны дундаас 173.0 мянгаар бага байна.

Том малын зүй бус хорогдол

	1991-1995 оны дундаж	1994	1995	1996	1997	1998	1999
Тэмээ	16.6	9.5	7.5	8.4	6.0	6.3	6.9
Адуу	76.7	41.6	48.1	53.2	45.1	50.7	72.8
Үхэр	132.9	78.3	84.6	79.8	110.6	111.4	127.0
Хонь	579.1	423.8	403.2	288.7	278.9	344.2	344.9
Ямаа	167.7	136.8	130.5	156.7	177.1	273.0	248.4
Бүгд	973.0	690.0	673.9	586.8	617.7	785.7	800.1

Оны эхний малд зүй бус хорогдолын эзлэх хувь

	1991-1995 оны дундаж	1994	1995	1996	1997	1998	1999
Тэмээ	3.7	2.6	2.0	2.3	1.7	1.8	1.9
Адуу	3.4	1.9	2.0	2.0	1.6	1.8	2.4
Үхэр	4.7	2.9	2.8	2.4	3.2	3.1	3.4
Хонь	4.0	3.1	2.9	2.1	2.1	2.4	2.3
Ямаа	2.9	2.2	1.8	1.8	1.9	2.7	2.2
Бүгд	3.8	2.7	2.5	2.1	2.1	2.5	2.4

1998-1999 оны өвөл, хавар Төв, Завхан, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай аймаг болон нийслэлийн зарим сум, дүүргийн нутагт цас их орж, бэлчээрийн хүндрэл учирснаас шалтгаалан дээрхи аймаг, хотын дүнгээр 445.0 мянган том мал зүй бусаар хорогдсон нь улсын хэмжээний нийт хорогдолын 55.6 хувийг эзлэж байна. (Хавсралтын хуудасны дугаар 21)

Том малын зүй бус хорогдлын 25.7 хувь буюу 206.0 мянга нь өвчнөөр, 25.7 хувь буюу 205.9 мянга нь гэнэтийн аюулаар хорогдов.

1961 оноос хойш малын зүй бус хорогдол хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага хорогдол гарсан		Хамгийн их хорогдол гарсан	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	510.3	1989	2663.8	1968
Тэмээ	6.0	1997	66.3	1966
Адуу	41.6	1994	235.3	1968
Үхэр	52.3	1974	278.9	1993
Хонь	278.9	1997	1606.3	1968
Ямаа	89.3	1989	574.8	1968

Малын хээл хаялт, сувайралт. 1999 оны оны хээлтэгч малын 13.8 хувь буюу 1913.0 мянга нь хээл хаяж, сувайрсан нь сүүлийн 40 шахам жилд үзэгдээгүй тоо хэмжээ бөгөөд 1991-1995 оны дундажаас 369.6 мянга, өмнөх оныхоос 413.0 мянгаар нэмэгдсэн байна.

Өмнөговь, Баянхонгор, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг; Улаанбаатар хот оны эхний хээлтэгч малынхаа 17.1-21.7 хувиас дээрхи шалтгаанаар төл авч чадсангүй. (Хавсралтын хуудасны дугаар 22-24)

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо (мян.тол)

	Төл өгөөгүй хээлтэгч мал бүгд				үүнээс сувайрсан		
	1991-1995 дундаж	1998	1999	1999\1998 хувь	1990-1995 дундаж	1998	1999
Ингэ	14.1	8.5	9.3	109.4	11.3	7.0	7.7
Гүү	182.1	180.2	220.0	122.1	138.7	125.6	159.2
Үнээ	236.3	246.3	266.2	108.1	189.0	184.3	203.1
Эм хонь	767.0	518.4	647.6	130.1	538.6	352.5	470.9
Эм ямаа	343.9	546.5	742.9	135.9	205.8	298.3	417.6
ДҮН	1543.4	1500.0	1913.0	127.5	1083.4	967.8	1258.5

Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь

	Бүгд			үүнээс: сувайрсан		
	1991-1995	1998	1999	1991-1995	1998	1999
Ингэ	12.1	8.7	9.5	9.7	7.1	7.8
Гүү	31.3	23.0	26.3	23.8	16.0	19.0
Үнээ	21.8	18.0	18.6	17.4	13.4	14.2
Эм хонь	10.9	8.1	10.1	7.7	5.5	7.1
Эм ямаа	12.7	12.5	15.2	7.6	6.7	8.6
ДҮН	13.4	11.5	13.8	9.3	7.4	9.1

1961 оноос хойш эх малын хээл хаялт, сувайралт хамгийн бага болон их гарсан жил

	Хамгийн бага		Хамгийн их	
	мян.тол	он	мян.тол	он
Бүгд	645.8	1963	1913.0	1999
Ингэ	8.5	1998	26.4	1973
Гүү	152.3	1995	333.6	1973
Үнээ	106.1	1962	326.0	1981
Эм хонь	190.6	1962	913.0	1993
Эм ямаа	124.7	1963	558.1	1968

Хээлтээгч, хээлтүүлэгчийн тохироо. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад одоо улсын дунджаар 67 эм хонь, 65 эм ямаа ногдож, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан хэвээр байна. Энэ байдал эх малын сувайралт нэмэгдүүлэхэд нөлөөлж, мал өсгөх багагүй нөөц бололцоог алдаж байна.

1990 онд улсын хэмжээгээр 7786.1 мянган эм хонь байхад үржлийн ажилд 242.7 мянган хуц ашиглагдаж байсан бол 1999 онд 6846.5 мянган эм хонинд 101.9 мянган хуцтай байна.

Хээлтүүлэгч малын тоо (мян.тол)

	Бүгд				үүнээс: шинээр тавьсан		
	1990	1998	1999	1999\1998	1990	1998	1999
Буур	4.1	4.8	4.7	97.9	66.0	0.1	0.1
Азрага	70.5	119.4	123.3	103.3	0.9	1.7	1.3
Бух	59.5	60.7	56.3	92.8	2.5	1.7	1.1
Хуц	242.9	106.1	101.9	96.0	20.9	5.5	1.6
Ухна	73.6	79.1	74.9	94.7	7.5	3.6	0.9
ДҮН	450.6	370.1	361.1	97.6	31.9	12.6	5.0

Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгч малын тоо

	Үржлийн норм	1990	1995	1996	1997	1998	1999
Ингэ	20-25	34	21	21	20	21	22
Гүү	12-15	8	7	7	7	7	8
Үнээ	35-45	19	20	21	23	24	26
Эм хонь	25-30	32	57	57	61	63	67
Эм ямаа	25-30	33	53	54	59	62	65

Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл, Өмнөговь аймагт ухна, Архангай, Төв, Сүхбаатар, Хөвсгөл аймагт хуц их дутагдалтай байна. (Хавсралтын хуудасны дугаар 25)

Малын хэрэглээний зарлага. Оны эхны нийт малын 26.6 хувьтай тэнцэх 8743.9 мянган малыг хүнсний хэрэгцээнд зарцуулсан нь 1998 оныхоос 1.2 сая толгойгоор нэмэгдсэн байна.

1999 онд оны эхний тэмээний 9.0 хувь, адууны 11.5 хувь, үхрийн 21.7 хувь, хонины 29.9 хувь, ямааны 28.5 хувийг хүнсний хэрэглээнд зарцуулжээ.

Сүүлийн 8 жилийн байдлаар өнгөрөгч онд хүнсний хэрэглээнд хамгийн олон мал зарцуулсан жил болов.

Ноднин жил зарим аймагт зуншлага муу болж мал өвөлжүүлж хаваржуулахад хүндрэл гарах төлөвтэй болсноос шалтгаалж малыг урьд жилүүдээс илүүтэй тоогоор нядалсан байна. Тухайлбал Дундговь, Завхан, Өвөрхангай аймагт 1998 оныхоос 111.6-221.0 мянган толгой мал илүү нядалжээ.

Малын нийт хэрэглээний зарлага. (мян.тол)

	1986-1990 оны дундаж	1991-1995 оны дундаж	1991	1995	1997	1998	1999
Бүгд	7559.8	7219.3	8930.5	6567.3	6920.0	7511.4	8743.9
Тэмээ	38.9	59.4	93.6	31.6	35.8	30.8	31.9
Адуу	201.7	203.5	273.8	163.5	304.1	299.8	350.7
Үхэр	544.3	551.5	684.6	523.9	697.4	755.6	809.4
Хонь	5311.3	5110.1	6174.6	4627.1	4055.1	4216.7	4397.9
Ямаа	1463.6	1294.8	1703.9	1221.2	1827.6	2208.3	3154.0

Оны эхний малд эзлэх хувь

	1986-1990 оны дундаж	1991-1995 оны дундаж	1991	1995	1997	1998	1999
Бүгд	32.7	28.2	34.5	24.5	23.6	24.0	26.6
Тэмээ	7.0	13.2	17.4	8.6	10.0	8.7	9.0
Адуу	9.8	9.0	12.1	6.8	11.0	10.4	11.5
Үхэр	21.5	19.4	24.0	17.4	20.1	20.9	21.7
Хонь	39.4	35.4	40.9	33.6	29.9	29.8	29.9
Ямаа	32.5	22.7	33.2	16.9	20.0	21.5	28.5

Сүргийн бүтэц. Нийт сүргийн 33.9 хувь нь төл, өсвөр насны, 42.2 хувь нь хээлтэгч, 22.9 хувь нь нас гүйцсэн эр мал, 1.1 хувь нь хээлтүүлэгч мал байна.

Бог малд хээлтэгчийн эзлэх хувь урьд оныхоос 0.3-0.4 пунктаар буурчээ.

Сүргийн бүтэц (хувиар)

	Төл, өсвөр насны			Нас гүйцсэн эр		
	1990	1998	1999	1990	1998	1999
Тэмээ	32.7	30.3	27.5	36.1	40.9	42.7
Адуу	37.6	36.5	32.1	34.4	32.3	34.8
Үхэр	49.8	44.8	45.8	8.5	15.1	14.9
Хонь	38.4	34.1	34.0	8.5	19.8	20.3
Ямаа	35.2	29.3	30.4	16.2	20.4	25.1
ДҮН	38.8	33.9	33.9	13.0	22.6	22.9

үргэлжлэл

	Хээлтэгч			Хээлтүүлэгч		
	1990	1998	1999	1990	1998	1999
Тэмээ	26.2	27.5	28.5	0.8	1.3	1.3
Адуу	24.9	27.3	29.1	3.1	3.9	3.9
Үхэр	39.6	35.4	37.9	2.1	1.6	1.5
Хонь	51.6	45.4	45.1	1.5	0.7	0.7
Ямаа	47.3	44.2	43.8	1.3	0.7	0.7
ДҮН	46.6	42.3	42.2	1.6	1.1	1.1

Сүүлийн жилүүдэд сүргийн бүтцэд томоохон өөрчлөлт гарлаа. 1999 онд нас гүйцсэн эр малын тоо 7.7 сая толгойд хүрсэн нь 1990 оныхоос 2.3 дахин буюу 4.3 сая толгойгоор өссөн байна.

Энэ хугацаанд эр ямааны тоо 3.3 дахин, эр үхэр, хонины тоо 2.3-2.4 дахин нэмэгджээ.

Нас гүйцсэн эр малын тоо (мян.тол)

	1990	1997	1998	1999	1999\1998	
					хувь	зөрүү
Ат	193.8	146.2	145.8	151.7	78.3	-42.1
Морь	778.2	954.2	986.9	1102.1	141.6	323.9
Шар	243.4	558.4	562.5	568.2	233.4	324.8
Эр хонь	1286.4	2886.8	2904.8	3081.3	239.5	1794.9
Эр ямаа	831.8	2645.2	2849.2	2774.8	333.6	1943.0
ДҮН	3333.6	7190.8	7449.3	7678.1	230.3	4344.5

II.2. Тэжээвэр амьтад.

1999 оны эцэст 21.9 мянган гахай, 78.1 мянган шувуу, 662 цаа буга, 1491 илжиг, 1154 бүл зөгий тоологдов. 1998 оныхоос гахайн тоо 2.0 мянга, шувууны тоо 11.5 мянгаар өссөн байна.

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөж, үржүүлдэг өрхийн тоо

	1990	1995	1997	1998	1999	1999\1998
Гахай (мян.тол)	134.7	23.5	20.8	19.9	21.9	110.1
Шувуу (мян.тол)	326.2	99.3	65.1	66.6	78.1	117.3
Цаа буга	3231	900	619	643	662	103.0
Илжиг	1018	913	953	1510	1491	98.7
Зөгий бүл	4768	1165	977	1057	1154	109.2
Туулай	7179	118	105	193	189	97.9
Үнэг	1251	568	50	28	45	160.7
Гахайтай өрхийн тоо (мян)	15.7	4.2	2.9	2.9	3.4	116.8
Шувуутай өрхийн тоо (мян)	1.3	2.2	2.1	3.4	2.0	57.5

Нийт гахайн тоо 1998 оныхоос 11 аймаг, хотод өссөний дотор Дорноговь Дорнод, Ховд аймагт 1.8-1.9 дахин өсчээ. Шувууны тоо 14 аймаг, хотод өссөн байна. (Хавсралтын хуудасны дугаар 27 – 29)

1999 онд аминдаа гахайтай өрх 3.4 мянга, шувуутай өрх 2.0 мянга болсон нь 1998 оныхоос гахайтай өрх 496-аар өсч, шувуутай өрх 1445-аар буурсан байна.

Одоо нийт гахайны 86.0 хувь, шувууны 21.2 хувь хувийн аж ахуйд байна.

Гахай, шувууны тоо, өмчийн төрлөөр (мян.тол)

	Гахай				Үндсэн мэгж		
	1998	1999	1999\1998	Хувийн жин	1998	1999	1999\1998
Дүн	20.0	21.9	110.1	100.0	5.6	6.6	118.4
Үүнээс: хувийн	16.8	18.8	112.1	86.0	5.0	5.5	108.7

үргэлжлэл

	Шувуу				Өндөглөгч		
	1998	1999	1999\1998	Хувийн жин	1998	1999	1999\1998
Дүн	66.6	78.1	117.3	100.0	60.5	69.7	115.2
Үүнээс: хувийн	13.8	16.6	120.5	21.2	9.5	11.2	117.7

II.3. Малын бэлчээр , тэжээлийн хүрэлцээ, хангамж

Бэлчээрийн хүрэлцээ. Газар зохион байгуулах албаны 1999 оны тайлангаар манай улсын бэлчээр, хадлангийн талбайг 129.1 сая га гэж тогтоосон нь 1990 оныхоос 3.9 хувь буюу 4.8 сая гагаар нэмэгджээ. Энэ хугацаанд малын тоо хонин толгойд шилжүүлснээр 72 сая болж 30.2 хувь буюу 16.7 сая толгойгоор өссөн байна.

Малын тоо толгой өссөнтэй холбогдон 100 га бэлчээр, хадлангийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 1989 онд 43 байсан бол 1998 онд 55, 1999 онд 56 болж нэмэгдэв.

Одоо 100 га бэлчээр, хадлангийн талбайд Орхон аймагт 1150 толгой, Улаанбаатарт 217, Дархан-Уул аймагт 211 толгой, Булган, Архангай, Хөвсгөл, Өвөрхангай, Төв аймагт 100-154 толгой (хонин толгойд шилжүүлсэн) мал ногдож байгаа нь аймгууд дотроос бэлчээрийн ачааллын хувьд хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Өнгөрсөн арван жилд ихэнх аймгийн бэлчээрт ногдох мал нэмэгдсэний дотор бэлчээрийн хүрэлцээ Орхонд 5 дахин, Дархан-Уул, Булган аймагт 1.9 дахин багасчээ.

Бэлчээрийн хүрэлцээ, аймаг, нийслэлээр

	Хадлан, бэлчээрийн талбай (мян.га)			100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо			1999\1989 хувь
	1989	1993	1999	1989	1993	1999	
АР	4536.3	4541.7	4255.0	85	89	150	176.7
БӨ	4178.6	4178.7	4412.6	56	43	54	96.7
БХ	9067.0	9067.0	11024.8	31	33	40	130.6
БУ	3173.1	3178.3	2708.5	79	85	154	194.5
ГО	8924.2	9491.4	12152.6	30	28	26	86.8
ДО	10592.4	10132.7	10260.6	20	17	24	119.5
ДД	9967.3	9966.9	11953.2	21	19	18	86.8
ДУ	7392.3	7377.9	7365.9	39	38	55	141.9
ЗА	6854.5	6855.7	6736.7	56	56	73	130.3
ӨВ	5982.9	5982.8	5913.3	68	72	104	152.9
ӨМ	14597.8	14597.7	12228.6	14	12	23	165.0
СҮ	6873.3	6876.6	8156.3	35	39	45	127.9
СЭ	1959.7	1946.0	1574.6	57	57	91	160.0
ТӨ	6040.7	5828.4	5203.9	62	65	100	161.6
УВ	5684.4	5684.2	5590.2	59	54	62	104.8
ХО	5995.5	5995.1	6576.2	50	52	50	100.0
ХӨ	5629.1	5355.3	5497.5	76	81	114	150.6
ХЭ	6405.8	6290.5	6422.2	50	45	59	117.3
ДА	190.2	190.2	198.0	110	165	211	192.2
УБ	58.2	58.2	289.3	691	1155	217	31.4
ОР	53.6	53.5	32.7	222	478	1150	517.8
ГС	-	459.7	538.6	-	41	55	-
ДҮН	124156.9	124108.5	129091.3	43	43	56	129.7

Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж. 1999 онд улсын хэмжээгээр 367.7 мянган тонн тэжээлийн нэгжтэй тэнцэх хэмжээний тэжээл үйлдвэрлэсэн нь 1998 оныхоос 11.3 хувь буюу 37.5 мянган тонноор өсчээ.

Үйлдвэрлэсэн тэжээлийг нэр төрлөөр нь авч үзвэл өнгөрсөн оныхоос байгалийн хадлан 7.2 хувиар нэмэгдэж, ногоон тэжээл 31.8 хувиар, бэлтгэсэн дарш 63.3 хувиар буурсан байна.

Тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ (тэжээлийн нэгжид шилжүүлснээр) 8 аймагт буурсны дотор Дорноговь, Завхан, Дархан-Уул, Увс аймгуудад 14.8-44.9 хувиар багасчээ.

1999 онд улсын хэмжээгээр 715.2 мянган тонн байгалийн хадлан бэлтгэсэн нь өнгөрсөн оныхоос 48.2 мянган тонн буюу 7 хувь өсчээ. Завхан, Дорноговь, Увс, Хөвсгөл, Баян-Өлгий аймагт бэлтгэсэн өвсний хэмжээ өмнөх оныхоос 12.1-49.6 хувиар буурсан байна. (Хавсралтын хуудасны дугаар 30-33)

Тэжээлийн хэмжээг нэр төрлөөр үзүүлбэл : (мян.т)

	1986\1990 дундаж	1991\1995 дундаж	1997	1998	1999	1999\1998 хувь
Байгалийн хадлан	1154.2	733.7	667.7	667.0	715.2	107.2
Сүрэл	114.1	47.2	16.1	15.9	14.3	89.9
Ногоон тэжээл	255.6	23.9	3.2	2.2	1.5	68.2
Гар тэжээл (тэж.нэгж)	21.7	9.6	11.3	20.3	13.0	64.0
Бэлтгэсэн дарш	277.7	66.2	10.3	7.9	2.9	36.7
Эрдэс тэжээл	61.9	18.1	19.4	26.2	24.1	92.0
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд(тэж.нэгж)	999.4	437.9	340.2	330.3	367.7	111.3

Сүүлийн жилд нийт тэжээлд хүчит, шүүст болон бүдүүн тэжээлийн эзлэх хувийн жин буурсан байна.

Үйлдвэрлэсэн тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж

	1994	1995	1996	1997	1998	1999
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
хүчит	9.5	7.4	3.3	4.2	1.6	0.9
шүүст	2.2	1.8	1.4	2.1	0.6	0.3
бүдүүн	88.3	87.4	92.5	90.0	91.7	88.7
бусад	-	3.4	2.8	3.7	6.1	10.1
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл (тэж.нэгж,кг)	6.5	7.1	5.5	4.9	4.7	5.1

1999 оны байдлаар хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл 1998 оныхоос 0.4 кг-аар өсч тэжээлийн нэгжээр 5.1 кг тэжээл ногдож байгаа нь нийт малыг 2.5 хоног тэжээх нөөцтэй гэсэн үг юм.

III. Малчдын тоо, тэдний соёл, ахуйн байдал

III.1. Малчдын тоо, насны бүлэг. 1999 оны жилийн эцсийн мал тооллогоор улсын хэмжээгээр 189.9 мянган малчин өрхөд 417.7 мянган малчид байна. Малчдын тоо өмнөх оныхоос 0.8 хувь буюу 3.3 мянгаар нэмэгдэв.

Нийт малчдын 55.9 хувь нь 16-34 насны залуучууд, 30.4 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах хүртлэх насны хүмүүс байна. Малчдын дотор тэтгэвэрийн насны хүмүүсийн хувийн жин буурч, 1997 онд 15.2 хувь байсан бол 1999 онд 13.7 хувь болжээ.

Өрх, малчдын тоо, бүрэлдэхүүн

	1994	1995	1997	1998	1999	1999\1998 хувь
Малчин өрх (мян)	167.3	169.3	183.6	187.1	189.9	101.5
Малчдын тоо (мян)	377.1	390.5	409.6	414.4	417.7	100.8
Үүнээс:16- 34 насны	204.8	225.2	223.9	231.3	233.7	101.0
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	106.3	95.4	123.4	125.4	126.8	101.1
Тэтгэврийн насны	66.0	69.9	62.3	57.7	57.2	99.1
Насны бүрэлдэхүүн (хувиар)	100.0	100.0	100.0	100.0	100.0	
Үүнээс:16- 34 насны	54.3	57.7	54.7	55.8	55.9	
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	28.2	24.4	30.1	30.3	30.4	
Тэтгэврийн насны	17.5	17.9	15.2	13.9	13.7	
Нэг малчин өрхөд ногдох малын тоо* (тол)	160	169	170	176	177	100.6

* Нийт малд оногдуулж бодсоноор

1998 онд нэг малчин өрхөд дунджаар 176 толгой мал ногдож байсан бол 1999 онд 177 толгой болов.

Архангай, Баян-Өлгий, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай аймгийн нэг малчин өрхөд 112-149 толгой мал ногдож байхад Сэлэнгэ, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Говь-Алтай Төв аймагт 213-284 толгой мал ногдож байна. (Хавсралт хүснэгтийн 34-р хуудаснаас үзнэ үү. Цаашид хавсралт хүснэгтийн хуудасны дугаарыг заана)

III. 2. Малчдын соёл, ахуйн зарим үзүүлэлт. 1999 оны байдлаар нийт малчин өрхийн дотор 25.7 мянган өрх цахилгаан эх үүсгэвэртэй, 30.9 мянган өрх телевизортэй, 12.8 мянган өрх авто машинтай, 29.8 мянган өрх мотоциклтэй, 3.1 мянган өрх трактортай байна.

Малчин өрхийн 13.5 хувь цахилгааны эх үүсгэвэртэй, 16.3 хувь телевизортэй, 6.7 хувь авто машинтай, 15.7 хувь мотоциклтэй, байгаа нь 1997 оны түвшингээс нэмэгджээ.

Баян-Өлгий, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймаг, Улаанбаатарын малчин өрхийн 50.3-73.5 хувь, Говьсүмбэр, Хэнтий аймгийн малчин өрхийн 21.5-22.5 хувь цахилгааны эх үүсгэвэртэй болсон байна.

Харин Архангай, Баянхонгор, Булган, Завхан, Увс аймгийн малчин өрхийн 1.8-5.4 хувь цахилгаантай байгаа нь аймгууд дотроос хамгийн доогуур түвшинд байна.

Баян-Өлгий, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймаг, Улаанбаатарын малчид автомашинаар, говийн аймгуудын малчид мотоциклоор бусад аймгуудынхаас илүү хангагджээ. (Хавсралт хүснэгтийн 35-36-р хуудаснаас үзнэ үү)

Малчин өрхийн соёл, ахуйн хангамжийн зарим үзүүлэлт

	Өрхийн тоо, мян			1999\1997 хувь	Малчин өрхийн тоонд эзлэх хувь	
	1996	1997	1999		1997	1999
Цахилгаантай	15.9	18.7	25.7	137.4	10.2	13.5
Телевизортэй	15.6	19.0	30.9	162.6	10.4	16.3
Автомашинтай	6.0	7.3	12.8	175.3	4.0	6.7
Мотоциклтэй	25.0	26.2	29.8	113.7	14.3	15.7
Трактортай			3.1			1.6

ДҮГНЭЛТ, САНАЛ

1999 онд манай улсын мал сүргийн тоо тэмээ, ямаанаас бусад төрөл дээр өсч, 33.6 сая толгойд хүрсэн нь урьд өмнө үзэгдээгүй тоо хэмжээ юм. 1990 оныхоос нийт малын тоо 7.7 сая толгойгоор өссөний дотор ямааний тоо 5.9 сая, үхэр 0.98 сая, адуу 0.9 сая, хонины тоо 108.3 мянгаар нэмэгдэж, тэмээний тоо 181.9 мянгаар буурсан дүнтэй байна.

Өнгөрсөн есөн жилд таван төрлийн малын харьцаанд болон дотоод бүтцэд томоохон өөрчлөлт гарлаа. Үхэр, бог малын дотор, эр малын эзлэх хувийн жин мэдэгдэхүйц нэмэгдсэн нь, сүргийн бүтцийг сайжруулсан өөрчлөлт юм. Харин малын тоо толгойн өсөлтийн дийлэнх ямааны өсөлтөөр хангагдаж, одоо нийт малын гуравны нэг нь ямаа боллоо. Энэ нь ямааны аж ахуй өрхийн орлогод тэргүүлэх байр эзэлж, харьцангуй ашигтай байгаатай холбоотой. Цаашид ч ямааны тоо өсөх төлөвтэй байна.

Мал өссөнтэй холбогдон сүүлийн найман жилд бэлчээрийн даацын ачаалал 1.3 дахин нэмэгдсэн байна. Орхон, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хот, өндөр уулын болон хангайн бүсийн зарим сумдад бэлчээрийн хомсдол бодит зүйл боллоо. Манай эрдэмтэд бэлчээрийн даацыг хонин толгойд шилжүүлсэн 60.0 сая мал гэж тооцоолсон бол одоо 72.0 сая мал болоод байна. Бэлчээрийн асуудал, зуншлага муудсан, цас зудад, нэрвэгдсэн аймаг, сумдад илүү хүнд тусах болов.

Мал өсч, сүргийн бүтэц сайжирсантай холбогдон манай улсын мах экспортлох боломж ихээхэн нэмэгдэв. Малын тоо толгойн жилийн дундаж хэмжээ 23.0 сая байсан 1961-1987 онуудад жилд дунджаар 137.2 мянган тонн амьдын жин бүхий мал, мах гадаадад гаргаж байжээ. Энэ бол жилдээ 2.2 сая мал экспортод гаргаж байсан гэсэн үг юм.

Өнгөрсөн жилийн гүйцэтгэлээс үзвэл 13.3 мянган тонн мах экспортолсныг амьдын жинд шилжүүлэн тооцвол 27.0 мянга орчим тонн болох бөгөөд энэ нь урьд гадаадад гаргаж байсан хэмжээний 20 хувьд ч хүрэхгүй байна.

Монгол улс мал аж ахуйн орон тул мал экспортлох явдлыг зохистой хэмжээнд байлгах шаардлагатай. Цаашдаа жилд амьдын жингээр 50.0-60.0 мянган тонн мах экспортлох боломжтой юм.

Ямаан сүргийн 22.9 хувь нь эр ямаа болжээ. Энэ нь ноолуурийн чанарт сөргөөр нөлөөлж байгаа нэг хүчин зүйл болж байна. Үндэсний статистикийн газраас зарим бүсийн аймагт явуулсан малын ашиг шимийн судалгаагаар малчид ноолуурын гарцад сонирхож байгаагаас чанарт анхаарахгүй байгаа нь харагдаж байв. Сүргийн дотор заазлалтыг зохистой хугацаанд нь хийж байх талаар малчдад нөлөөлөх эдийн засгийн бодлого шаардлагатай байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН

ГАЗРЫН ДАРГА.....Ч.ДАВААСҮРЭН

**Мал сүргийн тоогоор улсад эхний таван байрт
орох аймаг, аймаг, сумд, 1999 оны тооллогоор**

Аймгийн нэр	Малын тоо (мян.тол)	Сумын нэр	Малын тоо (мян.тол)
Нийт малын тоогоор			
1.Өмөрхангай	2956.6	1.Дундговийн Эрдэнэдалай	301.1
2.Баянхонгор	2475.1	2.Өвөрхангайн Богд	276.5
3.Завхан	2432.0	3.Хөвсгөлийн Цагаан-Уул	240.1
4.Хөвсгөл	2418.2	4.Өвөрхангайн Баянгол	237.4
5.Архангай	2335.5	5.Дундговийн Сайнцагаан	221.8
Тэмээгээр			
1.Өмнөговь	98.8	1.Өмнөговийн Мандал-Овоо	14.6
2.Баянхонгор	39.5	2.Өмнөговийн Ханбогд	13.7
3.Говь-Алтай	34.5	3.Баянхонгорын Баянлиг	11.2
4.Дорноговь	30.3	4.Өмнөговийн Гурвантэс	9.1
5.Дундговь	28.4	5.Дундговийн Өлзийт	8.3
Адуугаар			
1.Төв	303.6	1.Дундговийн Эрдэнэдалай	32.5
2.Архангай	298.1	2.Булганы Сайхан	31.2
3.Өвөрхангай	287.9	3.Архангайн Хашаат	28.5
4.Хөвсгөл	251.6	4.Архангайн Хотонт	28.1
5.Дундговь	216.8	5.Хөвсгөлийн Цагаан - Уул	27.4
Үхрээр			
1.Хөвсгөл	482.2	1.Өвөрхангайн Уянга	49.9
2.Архангай	464.0	2.Архангайн Тариат	42.3
3.Өвөрхангай	296.0	3.Архангайн Өндөр-Улаан	38.3
4.Завхан	271.4	4.Хөвсгөлийн Цагаан-Уул	37.2
5.Булган	264.4	5.Архангайн Эрдэнэмандал	33.4
Хониор			
1.Өвөрхангай	1423.1	1.Дундговийн Эрдэнэдалай	150.9
2.Завхан	1263.9	2.Өвөрхангайн Баянгол	142.3
3.Төв	1175.1	3.Хөвсгөлийн Цагаан-Уул	117.1
4.Архангай	1021.4	4.Архангайн Хашаат	109.6
5.Хөвсгөл	1000.1	5.Өвөрхангайн Баян-Өндөр	105.2
Ямаагаар			
1.Баянхонгор	1199.3	1.Өвөрхангайн Богд	171.8
2.Говь-Алтай	1029.9	2.Өмнөговийн Гурвантэс	120.2
3.Өвөрхангай	930.4	3.Баянхонгорийн Бууцагаан	112.5
4.Өмнөговь	907.5	4.Баянхонгорийн Баацагаан	109.8
5.Ховд	795.9	5.Баянхонгорийн Баянцагаан	104.1

1000-аас дээш малтай өрхийн тоо, аймаг, нийслэлээр, 1999 оны байдлаар

Аймаг	Бүгд	Ү ү н э э с		
		1000-1499 малтай	1500-2000 малтай	2001-ээс дээш малтай
Архангай	56	46	7	3
Баян-Өлгий	6	6	-	-
Баянхонгор	97	91	4	2
Булган	105	92	7	6
Говь-Алтай	59	52	4	3
Дорноговь	34	32	-	2
Дорнод	36	32	2	2
Дундговь	106	99	6	1
Завхан	89	77	8	4
Өвөрхангай	55	47	4	4
Өмнөговь	38	36	2	-
Сүхбаатар	78	73	3	2
Сэлэнгэ	21	17	1	3
Төв	136	126	9	1
Увс	52	47	3	2
Ховд	56	53	2	1
Хөвсгөл	40	37	1	2
Хэнтий	94	80	11	3
Дархан-Уул	6	6	-	-
Улаанбаатар	2	2	-	-
Орхон	2	2	-	-
Говьсүмбэр	9	8	1	-
ДҮН	1177	1061	75	41